



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2020 оны 8 дугаар
сарын 21-ний өдөр


Дугаар 32

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай


1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулж, явцыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Я.Содбаатар)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ



Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар
Ажлын хэсгийн Дэд ахлагч	-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон
Гишүүд:	-Сангийн сайд Ч.Хүрэлбаатар; -Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар; -Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр; -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл; -Гадаад харилцааны сайд Н.Энхтайван; -Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар; -Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн; -Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар; -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа; -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Энх-Амгалан; -Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн; -Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар; -Дорноговь аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Г.Эрдэнэцэцэг; -Шадар сайдын ахлах зөвлөх С.Янжинсүрэн;


-Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн;

-Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн;

-“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг.

Нарийн бичгийн дарга

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Анхбаяр.



Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа дараахь удирдамжийг мөрдөнө:

1. Бүтээн байгуулалтын ажил эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын өнөөгийн байдал, байгуулсан гэрээ, хэлэлцээр, барилга угсралтын ажлын төлөвлөлт, тулгамдсан болон шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай асуудлын хүрээнд боловсруулж батлах;

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хангах ажлыг хариуцсан чиглэл бүрээр шуурхай, хариуцлагатай зохион байгуулж, ажлын уялдаа холбоог сайжруулан, газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах нэгдсэн удирдлагаар ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж, явцыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллах.

---o0o---